

түвшинд тодорхойлж "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг" боловсруулан баталж. мөрдүүлэх;

> Хүний нөөцөө сургаж, бэлтгэх, мэргэшсэн чадварлаг нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

> Онц чухал объектуудын¹ хамгаалалтад инновацийг нэвтрүүлж, гадаад орнуудад ашиглагдаж байгаа арга, сүүлийн үеийн шинэлэг дэвшилтэд техник, технологийг ашиглах асуудлыг удирдлагын зүгээс менежментийн ухаанд тулгуурлан хөгжүүлэх;

> Онц чухал объектын хамгаалалт болон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулахад Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгжүүд /субъектүүд/-ийн дэмжлэгийг авах, харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж хөгжүүлэх, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг болно.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн хошууч Ш.Даваа-Эрдэнэ*

ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Цагдаагийн байгууллагаас гаргадаг гэмт хэргийн гаралт, түүнд дүн шинжилгээ хийсэн жил бүрийн тайлан, мэдээнээс дүгнэхэд сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт байнга өсөн нэмэгдэж байгаагын зэрэгцээ түүн дотор эзлэх хүнд, онц хүнд гэмт хэргийн тоо буурахгүй байна.

Нөгөө талаар шинэ төрлийн гэх гэмт хэргүүд тухайлбал, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хууль бусаар олж авах, борлуулах, тээвэрлэх, мөнгө угаах, мэдээлэл, технологийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд зохион байгуулалтын нарийн арга хэлбэрт шилжиж Монгол Улсын төдийгүй бусад улс орныг хамарсан гэмт бүлэглэлийн сүлжээнд хүртлээ тархсан байгаа нь сэтгэл түгшээж нийгэм, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлд нөлөөлөн сэтгэл түгшээж байна.

Шинэ төрлийн гэх дээрхи гэмт хэргүүд нь шинж байдлын хувьд урьд өмнө үйлдэгдэж байсан гэмт хэргүүдээс цоо шинэ арга, хэлбэрээр илэрч хүн

¹ Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байх объектын жагсаалт”-д хамаарах объектууд.

төрөлхтөн, дэлхий нийтэд нэн аюултай гэмт хэрэгт тооцогдох болж өнөө үед нийгмийн хор аюул нь улам бүр ихсэж байна.

Орчин үед гэмт хэрэгтнүүд шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэт аргыг ашиглан гэмт хэрэг үйлдэх болсон нь цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэхэд мэргэшлийн өндөр ур чадвар шаардаж эрс шинэчлэлт өөрчлөлт хийх цаг болсныг ч харуулж байна.

Нөгөө талаар гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж тогтоох уламжлалт арга, тактик өнөөгийн шаардлагад нийцэхгүй цаашлаад хуучин арга барилаар тэмцэх боломжгүй болж, харин уг ажиллагаанд бусад өндөр хөгжилтэй орны туршлагыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжлийн ололт амжилтыг ашиглах явдал зүй ёсоор шаардагдаж байна.

Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч арга барил, сэтгэлгээ нь нөгөө л хуучин хэвээрээ байсаар л байна.

Иймд шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ төвшинд гаргах, гэмт хэрэг илрүүлэхэд орчин үеийн техник хэрэгсэл, шинжлэх ухааны ололт дэвшлийг ашиглах, бусад улс орны цагдаагийн байгууллагад алба хаагчдыг сургаж мэргэшүүлэх, туршлагыг судалж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байгаа юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.4.4 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс хамгаалах орчин, нөхцлийг сайжруулна¹" гэж заасан байдаг.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар Тагнуулын байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 20 төрлийн; Авлигатай тэмцэх газар 8 төрлийн; Цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 182 төрлийн гэмт хэрэгтэй тус тус тэмцэх чиг үүрэгтэй байна. Цагдаагийн байгууллагын харьяаллын 182 төрлийн гэмт хэргээс 30 гаруй нь хар тамхи, хүний наймаа, мөнгө угаах зэрэг үндэстэн дамнасан шинжтэй, зохион байгуулалттай, гол төлөв нууц далд аргаар үйлдэгддэг манай улсын хувьд шинэ төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Шинэ төрлийн гэмт хэрэг гэдэгт Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцогдохоор тусгагдсан гэмт хэргүүд, Эрүүгийн хуульд урьд гэмт хэрэг гэж тооцогдсон, шинэ төрлийн аргаар үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд, Монгол Улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагаагүй боловч

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.nsc.gov.mn>

дэлхий нийтэд шинээр гарах болсон гэмт хэргүүдийг хамааруулан тус тус авч үздэг. Өөрөөр хэлбэл шинэ төрлийн гэмт хэрэг гэдэгт эрүүгийн хууль тогтоомжид шинээр гэмт хэрэгт тооцохоор оруулсан, түүнчлэн гэмт хэргийг сүүлийн үеийн шинэ тутам арга хэрэгсэл, шалтгаан, нөхцлөөр үйлдэгдэж байгаа нийгмийн хор аюулаар их гэмт үйлдэл эс үйлдэхүйг хэлнэ.

Шинэ төрлийн гэмт хэрэгт дараах гэмт хэрэг хамаардаг.Үүнд:

Хүн худалдах, худалдан авах /ЭХ-ийн 113 дугаар зүйл/, Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэх, гуйланчлалд татан оролцуулах /ЭХ-ийн 115 дугаар зүйл/, Садар самууныг сурталчлах /ЭХ-ийн 123 дугаар зүйл/, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах /ЭХ-ийн 124 дүгээр зүйл/, Мөнгөн тэмдэгт үнэт цаас хуурамчаар үйлдэх, борлуулах /ЭХ-ийн 176 дугаар зүйл/, Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах, /ЭХ-ийн 200 дугаар зүйл/, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах тээвэрлэх, илгээх борлуулах болон мансууруулах бодис агуулсан тарих /ЭХ-ийн 192, 194, 195 дугаар зүйл/, Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх , зорчих журам зөрчих /ЭХ-ийн 240 дүгээр зүйл/, Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ЭХ-ийн 226-229/, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх /ЭХ-ийн 175 дугаар зүйл/, Хээл хахууль авах, өгөх зуучлах /ЭХ-ийн 268-270 дугаар зүйл/, Хориглосон үйлдвэрлэл худалдаа эрхлэх Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэсэн гэмт хэргүүд байдаг.

Манай улс НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцид нэгдэн орсон 150 гаруй орны нэг. Энэ утгаараа Монгол Улсын Эрүүгийн хуулийг Олон улсын Эрүүгийн хууль тогтоомжийн үзэл санаанд нийцүүлэн боловсронгуй болгон ижилтгэх, зарим зүйл заалтыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах нь өнөө үед тулгамдсан асуудал болоод байна.

Иймд эрүүгийн хэргийг Гэмт хэргийн тухай хууль болгон өөрчилж шинэ төрлийн гэмт хэргийг хэрхэн тусгаж оруулах асуудал сөхөгдөж байна. Шинэ төрлийн гэмт хэрэг гэх нэр томъёонд орж буй эхний асуудал бол үндэстэн дамнасан авлигын хэрэг.

Дэлхийн улс төр, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага нь авлигын үндэстэн дамнасан хэлбэрээр үүсэж, хөгжих боломжийг бүрдүүлж байдаг. Манай улсад бол “үндэстэн дамнасан авлига” бий болох, үр дагаварт нь улс орон, газар нутгаа худалдах гэмт хэрэг бий болох үндэс суурь нэгэнт бүрэлдэн тогтсон гэдгийг судлаачид дүгнэсэн. Үндэстэн дамнасан авлига нь аливаа улс оронд

эдийн засгийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, эсхүл тийм боломж олж авах, түүнчлэн ямар нэгэн давуу байдал олж авахын тулд гадаадын албан тушаалтныг худалдан авах. эсхүл гадаадын иргэд үндэсний албан тушаалтныг хахуульдаж авах хэлбэрээр илэрдэг аж. Үндэстэн дамнасан авлига нь Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт явдал гэсэн үндсэн хүрээг хамардаг.

Монгол Улс дотоодын авлигаас гадна үндэстэн дамнасан авлига гэгчийг урьчилан харж, сөрөн зогсох бодлого, аргачлал боловсруулж, таслан зогсоох шаардлага нэгэнт бий болсон. Эрүүгийн хууль батлагдсан 2004 оноос хойш сүүлийн арван жилд Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлээр 65 гэмт хэрэгт 90 хүн, хуулийн 269 дүгээр зүйлээр 18 хэрэгт 71 хүн ял шийтгүүлснээс гадна хуулийн 170 дугаар зүйлээр (хууль бусаар шан харамж авах) гурван хүн ял шийтгүүлжээ. Энэ бол дотоодын авлигын хэргээр шийтгүүлсэн иргэдийн тоо. Харин үндэстэн дамнасан авлигын хэрэг Монгол Улсын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн практик өнөөдөр байхгүй. Энэ нь үндэстэн дамнасан авлигын хэрэг Монгол Улсад байхгүй гэсэн үг биш. Ийм төрлийн хэргийг илрүүлж чадахгүй байгаагийн нэг илрэл гэж ойлгож болно.

Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалт, төсөл, түүний хэрэгжилт, мөн тендерт тавигдах хяналт сул байгаа. Энэ нь дээрх төрлийн гэмт хэргийг илрүүлэх талаар ямар нэгэн механизм байхгүй. Олон улсын хамтын ажиллагаа төлөвшөөгүй учраас үндэстэн дамжсан авлига цэцэглэн хөгжих үндэс суурь болж байна гэж үзэхээс өөр аргагүй. Авлигын хэлцэл хилийн гадна явагдаж, авлигын мөнгө гадаадын банкинд төвлөрч, угаагдаж “цэвэршиж” байна. Үүнд (Офшор банк, татваргүй бүсэд байгуулагдсан аж ахуйн нэгж) ордог. Төрийн албан тушаалтанд олон улсын хэлцлийн хүрээнд ихээхэн хэмжээний мөнгө атгуулахад хөнгөн, аюулгүй байдаг аж. Тэр ч бүү хэл, авлигын хэлцэл нэг улсад хийгдэж байгаа ч хөрөнгийг хилийн цаана шилжүүлэх шаардлага нь энэ төрлийн хэргийг олон улсын шинжтэй болгодог байна. Авлига нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдээс ашиглаж байгаа хамгийн шалгарсан арга бөгөөд хүчирхийлэн ашиглахаас илүү найдвартайд тооцогддог аж. Хээл хахууль хэлбэрээр өгч байгаа мөнгө нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн толгойлогчдоос “ажил хэрэгч”-үүднээс зайлшгүй зарцуулах хөрөнгө, нэг ёсны хөрөнгө, эсхүл тэднийг сайн хөрөнгө оруулагч гэсэн халхавч болохын хамт энэ байдлаараа амжилт олох болон ял шийтгэлээс зугтах боломжийг нэмэгдүүлдэг байна.

АНУ нь анх удаа аж ахуйн үйл ажиллагааны явцад гадаадын албан тушаалтныг худалдан авахыг хориглох тухай, тодруулбал Гадаадын авлигын практикийн тухай Акт (Foreign Corrupt Practices Act) хэмээн нэрлэгдэх энэ хуулийг анх 1977 онд баталсан. Энэ нь XX зууны 70-аад оны дунд үед АНУын

400 гаруй компани гадаадын Засгийн газрын албан тушаалтан, улс төрийн зүтгэлтэн болон улс төрийн намуудад 300 сая орчим доллар өгсөн тухай сэжигийг тусгай комиссоос шалгасны үр дүнд батлагдсан байна.

Тэгэхээр дотоодын авлигаасаа салж чадаагүйгээр манай улс саяхан Олон улсад авлигатай орны хоёрдугаарт бичигдсэн мэдээ ирсэн байдаг. Дотоодын авлигаасаа ангижраагүй байтал үндэстэн дамнасан авлигын хэрэг гэх зүйл хуулийнхны санааг ийн зовоож эхэлжээ.

Шинэ төрлийн хэрэгт мөн хүн худалдаалах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаах, терроризм гэх мэт хэллэгүүд орж ирж буй ч энэ нь дэлхий нийтэд шинэ төрлийн гэж авч үзэхээс өөр аргагүй зүсээ хувиргасан, далд хэлбэр рүү шилжсэн нь анхаарал татах асуудлын нэг болж буй аж. Тухайлбал, терроризм гэдэг бол монголчууд бидний хувьд хоёр том гүрний дунд оршиж буй учир энэ аюулаас хол мэт санагдавч, өнөө үеийн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт гар хөл хүрэхгүй газар байхгүй болсных юм.

Иймд шинэ төрлийн гэж нэрлэж буй дээрхи гэмт хэргүүдтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг олон улсын жишигт нийцсэн арга ажиллагаа, техник технологийн дэвшилд хүрсэн багаж, тоног төхөөрөмж зэргийг нэвтрүүлэн явуулах нь одоо юу юунаас илүү чухал болоод байна. Иймд нөхцөл боломж бүрдсэн үед энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гарах бөгөөд мөн түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч субъектийн ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэхэд ч онцгой анхаарах ёстой.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
цагдаагийн хошууч Э.Золбаатар*

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, хүн амын сэтгэлгээнд өөрчлөлт орж, гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч байгаа өнөө үед цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байна. Иймд цагийн нөхцөл байдлыг бодитой үнэлж хуулийн хүрээнд оновчтой шийдвэр гаргаж, төр, ард иргэдийнхээ амар амгалангийн төлөө байгууллага, алба хаагч бүр өөрийн сэтгэл, оюун санаагаа чилээж, мэдлэг, чадвараа бүрэн дайчлан шинэлэг байдлаар ажиллах явдал зүй ёсоор тавигдаж байна.